



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК


МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

Улаанбаатар
2018



МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Нийт мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 28.6 хувиар өсчээ




Нийт мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 297.6 тэрбум ₮-өөр өсөв



Мөнгөний нийлүүлэлт буюу М2 мөнгө өмнөх оны мөн үеэс 28.6 хувиар өсч 17.3 их наяд төгрөг боллоо. М2 мөнгөний жилийн өсөлтийн 55 хувийг төгрөгийн хадгаламж, 24 хувийг валютын харилцах, 17 хувийг төгрөгийн харилцах, 4 хувийг валютын хадгаламж бүрдүүлжээ.

Нийт хадгаламжийн хэмжээ 11.8 их наяд төгрөгт хүрснээс 84 хувь нь буюу 9.9 их наяд төгрөг нь иргэдийн, 16 хувь буюу 1.8 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Иргэдийн хадгаламжийн 19 хувийг, байгууллагын хадгаламжийн 32 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Нийт хадгаламжийн хэмжээ 11.8 их наяд ₮-т хүрлээ




Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдээс валютын харилцах болон хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө өмнөх сараас буурч бусад бүрэлдэхүүн хэсгүүд өссөнөөр М2 мөнгө тайлант сард 1.7 хувиар өссөн байна. Нийт төгрөгийн харилцахын өсөлтөд хувийн байгууллагын харилцах 226 тэрбум төгрөгөөр, иргэдийнх 38 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Иргэдийн хадгаламж 224 тэрбум төгрөгөөр өсч байгууллагуудынх 22 тэрбумаар буурсан байна. Харин валютын харилцах буурахад хувийн байгууллагын харилцах буурсан нь голлон нөлөөлжээ.

М2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 18.6 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА) -1.2 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх сартай харьцуулахад ГЦА 450 тэрбум төгрөгөөр буурч, ДЦА 750 тэрбум төгрөгөөр өссөн байна. ГЦА-ын бууралтанд засгийн газрын Дим сан бондын эргэн төлөлт гол нөлөө үзүүлсэн бол, ДЦА-ын өсөлтөнд дотоод эдийн засагт гаргасан зээлийн өсөлт нөлөөлжээ.

БАНКУУДЫН ЗЭЭЛ


Нийт зээлийн үлдэгдэл 15.3 их наяд ₮-т хүрч, жилийн 19.3%-р өсөв




Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 19.3 хувиар, үүнээс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 23.9 хувиар өсч 7.5 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх 15.9 хувиар өсч 7.7 их наяд төгрөгт тус тус хүрчээ.

Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл 1,310.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 96.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнээс хамгийн их өсөлттэй нь барилгын салбарын чанаргүй зээлийн үлдэгдэл байна. Өмнөх сартай харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 0.4 нэгж хувиар өсч, хугацаа хэтэрсэн зээлийнх 0.9 нэгж хувиар буурсан байна.

Чанаргүй зээлийн үлдэгдэл, тэрбум ₮, салбаруудаар




Тайлант сард 2166.1 тэрбум ₮-ийн зээл шинээр олгож, 1733.1 тэрбум ₮ эргэн төлөгдлөө



Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 30.2 тэрбум төгрөгөөр, төлөгдсөн зээл 97.3 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Тайлант сард олгосон зээлийн 52.7 хувийг хувийн байгууллагад, 45.5 хувийг иргэдэд олгосон зээл бүрдүүлж байна. Өмнөх сартай харьцуулахад хувийн байгууллагад олгосон зээл 6 хувиар өсч, иргэдэд олгосон зээл 3 хувиар буурчээ. Энэ нь хэрэглээний шинж чанартай зээлийн өсөлт хумигдаж, бизнесийн зээлийн өсөлт нэмэгдэж байгааг илэрхийлж байна.

Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 84.2 хувийг, чанаргүй зээлийн 82.2 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.

Чанаргүй зээл нийт зээлийн 8.6%, Хугацаа хэтэрсэн зээл 5.4% байна




Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл өмнөх сараас 261.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс худалдааны салбарын зээлийн үлдэгдэл 150.0 тэрбум төгрөгөөр, барилгын салбарынх 33.6 тэрбум төгрөгөөр, уул уурхайн салбарын зээл 6.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, боловсруулах салбарын зээл 23.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хувийн байгууллагад олгосон зээлийн дийлэнх хэсгийг худалдаа, боловсруулах үйлдвэр, барилгын салбар эзэлж байна




Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 140.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд цалин, тэтгэврийн зээл 87.2 тэрбум төгрөгөөр, автомашины зээл 19.8 тэрбум төгрөгөөр, хадгаламж барьцаалсан зээл 11.2 тэрбум төгрөгөөр, картын зээл 2.3 тэрбумаар өссөн нь голлон нөлөөлжээ.

Иргэдийн зээлийн 43.0 хувийг орон сууцны зээл (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар) бүрдүүлж байна



ЖДҮ-ийн зээлийн дийлэнх хэсгийг худалдааны салбар, боловсруулах үйлдвэрлэлийн зээл эзэлж байна



ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 3.0 их наяд төгрөгт хүрснээс 29.2 хувийг худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 19.1 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 11.9 хувийг барилгын салбарт олгосон байна. ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 3.7 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 12.3 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан байна.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Ипотекийн зээлийн үлдэгдэл 4.3 их наяд төгрөгт, зээлдэгчдийн тоо 93,880-г хүрчээ. Нийт зээлийн үлдэгдлийн 927.8 тэрбум төгрөг буюу 21.4 хувь нь орон нутаг дахь банкны салбаруудаас олгосон зээл байгаа бол 763.4 тэрбум төгрөг буюу 17.6 хувь нь тухайн орон нутагт орон сууц худалдан авахад зарцуулагджээ.

Ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 35.4 тэрбум төгрөгөөр өсөв



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 76.3 хувь нь хөтөлбөрийн зээл, 21.3 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.4 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна. Харин орон нутгийн ипотекийн зээл¹-ийн 77.8 хувь нь хөтөлбөрийн зээл, 21.3 хувь нь өөрийн эх үүсвэрээр, 0.8 нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

Нийт ипотекийн зээлийн 76.3 хувь нь хөтөлбөрийн зээл байна



Тайлант сард банкууд 1,142 зээлдэгчид 82.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос 42.0 хувь нь хөтөлбөрийн, 58.0 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байна.


Ипотекийн зээлийн хувьд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл буурсан байна



Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 63.8 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 34.3 хувийг

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 96.2 хувь нь хэвийн, 2.0 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.8 хувь нь чанаргүй зээл байна.

Нийт шинээр олгосон зээлийн хүү 0.5 нэгж хувиар буурчээ



Тайлант сард ипотекийн зээлтэй нийт зээлдэгчдийн тоо 93,880 байгаагийн 63.8 хувь нь 2 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой зээлдэгчид байна.


¹ Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

хөтөлбөрийн зээл, 1.9 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 90.6 хувь буюу 3.9 тэрбум төгрөг 80м2 хүртэлх талбай бүхий орон сууц худалдан авахад зарцуулагджээ.

Нийт ипотекийн зээл авсан зээлдэгчдийн 76.1 хувь нь 25-45 насны иргэд байгаа бөгөөд эдгээр зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 79.9 хувь нь ногдож байна.

Ипотекийн зээлийн 82.4 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авахад зарцуулагджээ



ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ХАНШ


Тайлант сарын эцсийн байдлаар Монголбанкнаас зарласан төгрөгийн ханш БНХАУ-ын юань, БНСУ-ын вон болон Канадын долларын эсрэг бага зэрэг чангарч бусад голлох валютуудын эсрэг сулрав. Тайлант сарын 2 дугаар хагасаас төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларч 2464.6 төгрөгт хүрсэн бол сарын дундаж ханш 2432.3 төгрөг буюу өмнөх сараас 1.1 хувиар суларчээ.

Харин төгрөгийн БНХАУ-ын юаньтай харьцах дундаж ханш өмнөх сараас 0.3 хувиар чангарч 376.1 төгрөг байв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 371.8 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 377.8 төгрөг байлаа.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулрав



Төгрөгийн ханш юаны эсрэг чангарсан байна




ХҮҮ


2018 оны 6 дугаар сард шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 18.0 хувьтай байна. Харин эдгээр зээлийн дийлэнх нь 14-18 болон 20-22 хувийн хүүн дээр гарсан зээл байна.

Мөн тухайн сард шинээр олгосон гадаад валютын зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 10.2 хувьтай байна. Харин гадаад валютын зээлийн дийлэнх нь 8-12 хувийн хүүн дээр олгогдсон байна.


Төгрөгийн зээлийн хүүний тархалт




Гадаад валютын зээлийн хүүний тархалт



Иргэд, хувийн байгууллагад олгосон төгрөгийн зээлийн хэмжээ, хүү




Иргэдээс татсан төгрөг, валютын хадгаламж




Иргэдэд шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 6 дугаар сарын байдлаар 19.2 хувь болж өмнөх сараас 0.2 нэгж хувиар буурсан байна. Гадаад валютын зээлийн ЖДХ өмнөх сараас 2.7 нэгж хувиар буурч 12.0 хувьтай байна.

Харин хувийн байгууллагад шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 16.5 хувьд хүрч өмнөх сараас 1.3 нэгжээр буурсан байна. Шинээр олгосон гадаад валютын зээлийн ЖДХ 9.9 хувьтай байна.

Иргэдэд шинээр олгосон төгрөгийн зээлийн хүүний тархалт



Хувийн байгууллагад шинээр олгосон төгрөгийн зээлийн хүүний тархалт



6 дугаар сард иргэдэд шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 18.0 хувьтай байна. Харин эдгээр зээлийн дийлэнх нь 16-18 болон 21-24 хувийн хүүн дээр олгогджээ.

Хувийн байгууллагад олгосон зээлийн хүүг эдийн засгийн салбараар



Шинээр хувийн байгууллагад олгосон гадаад валютын зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 16.5 хувьтай байна. Харин үүний дийлэнхийг 14-18 болон 20-22 хувийн хүүтэй олгожээ.

Тухайн сард хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн хүүг эдийн засгийн голлох салбаруудаар ангилан харвал мэргэжлийн, ШУ болон техникийн салбарт хамгийн өндөр буюу 20.5 хувийн хүүтэй зээл олгосон. Харин эрүүл мэнд болон нийгмийн үйл ажиллагааны салбарт хамгийн бага буюу 13.6 хувийн хүүтэй зээл шинээр олгожээ.

Тайлбар: Хашилтад тайлант сард тухайн салбарт олгосон зээлийн нийг олгосон зээлд эзлэх хувь

ИНФЛЯЦИ

Тайлант сард Улаанбаатар хотын жилийн инфляци 8.0 хувь байна. Энэхүү жилийн инфляцийн 5.0 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 3.0 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна. Хүнснээс бусад барааны үнэд хатуу түлш, шатахуун, хувийн дунд болон их дээд сургуулийн төлбөр, тамхины үнийн өсөлт гол нөлөө үзүүлсэн бол хүнсний барааны бүлгийн үнэд хонины мах, сүү, төмс, лууван, цөцгийн тосны үнийн өсөлт голлон нөлөөлжээ.

УБ хотын жилийн инфляци 8.0 хувь



УБ хотын хэмжээнд сарын инфляци 0.7 хувьтай гарснаас 0.4 нэгж хувийг хүнсний бараа, 0.3 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлт тайлбарлаж байна. Хүнсний барааны үнийн өсөлтийг хүнсний ногооны үнийн өсөлт голлон бүрдүүлж байгаа бол хүнснээс бусад бараанд агаарын зорчигч үйлчилгээ болон дотоодын аялал жуулчлалын үйлчилгээний үнийн өсөлт нөлөөлжээ.

УБ хотын сарын инфляци 0.7 хувь




ХАВСРАЛТ 1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа




Зураг 1.2. M2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц



Зураг 1.3. Нөөц мөнгөний бүтэц




Зураг 1.4. Төв банк, хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод актив




ХАВСРАЛТ 2. ЗЭЭЛ


Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа, гол салбараар




Зураг 2.3. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл




Зураг 2.4. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)



Зураг 2.5. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл




Зураг 2.6. Чанаргүй зээлийн дүн




ХАВСРАЛТ 3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Зураг 3.1. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр



Зураг 3.2. Ипотекийн зээлийн үлдэгдэл аймгуудаар



Зураг 3.3. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар



Зураг 3.4. Тайлант сард шинээр олгосон зээл




Зураг 3.5. Улаанбаатар хотын ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар




Зураг 3.6. Орон нутгийн ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар



Зураг 3.7. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он



Зураг 3.8. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Зураг 3.9. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт



Зураг 3.10. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл

